

18-20-нд хуралдсан АААН-ын нийт үндэсний бага хурал тодорхой заасан билээ. ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орон, түүний дотор БНМАУ үндэсний эвлэрлийн бодлогын ач холбогдлыг өндрөөр үнэлж, түүний үйл явц нь эргэлт буцалтгүй болно гэдэгт итгэл төгс байна.

¹ «Үнэн 1987—1—3

² АААН-ын нийт үндэсний II бага хурлын материал. Кабул, 1987. (дари хэлээр)

³ «Үнэн» 1988-1-16

⁴ АААН-ын нийт үндэсний II бага хурлын материал. Кабул, 1987. (дари хэлээр)

⁵ Мөн тэнд 5а Kabul new times. October 20. 1987

⁶ Мөн тэнд

⁷ Kabul new times. October 20—22. 1987

⁸ Kabul new times. October 22. 1987

⁹ АААН-ын нийт үндэсний II бага хурлын материал. Кабул, 1987 48- хуудас
дари хэлээр)

¹⁰ Мөн тэнд

¹¹ Kabul new times. October 21. 1987

¹² Азия и Африка N 12 (1987), с. 27

¹³ Үнэн 1987—7—8 N 162

¹⁴ Ж. Батмөнх, МАХН-ын XIX их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны
тайлан, цаашдын зорилт. УБ. 1986, 15-р тал

¹⁵ «Үнэн» 1988— —8

¹⁶ «Үнэн» 1987—11—10

¹⁷ Мөн тэнд

¹⁸ Consultative meeting of representatives of the communist and worker's parties
of Asian and Pacific region countries. УБ. 1987. p. 106.

БНХАУ ДАХЬ
ШИНЭТГЭЛ

ХКН-ЫН ХШ ИХ ХУРАЛ

Д. ШҮРХҮҮ

ХКН-ын ээлжит ХШ их хурал 1987 оны 10-р сарын 25-наас 11-р сарын 1-нд Бээжин хотноо хуралдав. Энэ их хурал нь нэлээд урт хугацаанд ХКН-аас улс төр, нийгэм-эдийн засаг, гадаад бодлогын салбарт баримтлах үндсэн чиг шугам, шинэтгэл, нээлттэй хаалганы бодлогыг цаашид гүнзгийрүүлэн түргэтгэх арга зам, эдийн засгийг хөгжүүлэх стратегийн чиглэлийг тодорхойлон зааснаараа онцлогтой юм.

46 сая гишүүдийг төлөөлсөн 2000 орчим төлөөлөгчид ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Жао Зыяны тавьсан Төв Хорооны тайлан илтгэл, ХКН-ын ТХ-ны Зөвлөхүүдийн

төв комисс болон сахилга батыг шалгах төв комиссын илтгэлүүдийг сонсон хэлэлцэж, ХКН-ын дүрмэнд оруулах өөрчлөлтийг батлав. Тус их хурлаар ХКН-ын Төв Хорооны 175 гишүүн, 110 орлогч гишүүн, Мөн түүнчлэн Зөвлөхүүдийн төв комисс, сахилга батыг шалгах төв комиссын шинэ бүрэлдэхүүнийг сонгов.

Жао Зыяны тавьсан «Хятадын өвөрмөц онцлогтой социализмын замаар урагшиль» тайлан илтгэлийн эхэнд шинэтгэл, нээлттэй хаалганы бодлого явуулах түүхэн шийдвэр гаргасан 1978 оны III бүгд хурлаас хойшхи 9 жилийн ололт, туршлагаа нэгтгэн дүгнэсэн байна. Энэ хугацаанд Хятад орны нүүр царай шинэчлэгдэн өөрчлөгдөж, үндэстний нийт бүтээгдэхүүн болон хот, хөдөөгийн хүн амын дундаж орлого 2 дахин өсчээ.

Олон үеийн турш үргэлжилж ирсэн нийт хүн амын хоол, хувцасны асуудал үндсэндээ шийдвэрлэгдсэн нь дээрх хугацаанд олсон гол амжилтын нэг юм. Улс ардын аж ахуй дахь тэнцвэрт харьцааны алдагдал нэлээд зүгширч, үндсэндээ жигд хөгжлийн замд оржээ. Аж ахуйн хөшүүн хойрго механизмыг эвдэж, гадаадтай харилцаагаа өргөжүүлснээр өргөн олон түмний идэвх санаачилга сэргэж, олон жил хүмүүсийн ухамсрыг чөдөрлөж байсан нэлээд хуучин ойлголтыг няцааж буй ажээ. Гэвч тайлан илтгэлд, амжилтандаа бардамнан сайрхах ямар ч үндэс байхгүй бөгөөд бодож байснаас ч их асуудал, бэрхшээл тулгарч байна гэж цохон тэмдэглэжээ.

Их хурал нийгэм-эдийн засгийн хөгжлийг түргэсгэх, аж ахуйн системийн шинэтгэлийн үйл явцыг гүнзгийрүүлэх зорилттой уялдан гарч ирсэн онолын зарим асуудлыг авч хэлэлцэв.

Улс орон Нийгмийн хөгжлийн ямар шатанд байгааг зөв олж тогтоох нь танин мэдэхүйн төдийгүй онол-практикийн асар их ач хол богдол бүхий нарийн төвөгтэй асуудал юм. Урьд ХКН-ын удирдлага энэ асуудалд ноцтой алдаа гаргаж, улмаар түүнийхээ үндсэн дээр явуулсан «зүүний» балмад бодлогын улмаас Хятад орны социалист байгуулалтад ихээхэн саад бэрхшээл учирч, ард түмэн олон жил ядуу зүдүү байдалд байж, асар их зовлон зүдгүүр амссан билээ. Тэр үед социализмын хөгжлийн үе шатыг өмчийг нийгэмчилсэн түвшнээр хэмжиж, хуваарилалтанд тэгшитгэх явдал ноёрхож байв. Энэ бүхэн олон түмний үзэл бодол, социализмын тухай ойлголт, түүнд итгэх итгэлд муугаар нөлөөлсөн юм. Сүүлийн жилүүдэд аж ахуйн системийг шинэтгэх явцад таваар-мөнгөний харилцаа, зах зээлийн механизм, аж ахуйн олон хэвшил, ялангуяа хувийн аж ахуйг хөгжүүлэхийг чухалчлах болсон нь өнөөгийн Хятадын удирдлагаас явуулж буй бодлогын шинж байдлын талаар тус орны дотоодод төдийгүй хилийн чанадад янз бүрийн ойлголт төрүүлэх болжээ. Иймээс ХКН-ын XIII их хурал Хятад орны нийгмийн байгуулал социалист болохыг нотлоод, социализмын эхний шатандаа байна гэж тодорхойлов. Гэхдээ энэ шат бол социализм байгуулж буй орон бүр зайлшгүй туулах дамжлага шат биш боловч хагас колони, хагас феодалын үндэс суурь дээр социалист нийгмийг байгуулж байгаа Хятад орны хувьд үйлдвэрлэх хүчний хоцрогдол, таваарын эдийн засгийн хөгжил сул байгаагаас нөхцөлдөн гарч ирсэн зайлшгүй дайран гарах өвөрмөц үе шат ажээ. Энэ үе шат нь Хятад орны хувьд үйлдвэрлэлийн хэрэгсэл дэх хувийн Өмчийг социалист ёсоор өөрчлөн байгуулж дууссан 50-иад оны дунд

үеэс эхэлж, «дөрвөн шинэчлэлтийг» хэрэгжүүлэх хүртэл наад зах нь 100 гаруй жил үргэлжилнэ гэж үзжээ.

Хятадын нийгмийн гол зөрчлийн талаар их хурлын баримт бичгүүдэд, социализмын эхний шатан дахь гол зөрчил бол ард түмний өсөн нэмэгдэж буй материаллаг болон соёлын эрэлт хэрэгцээ ба нийгмийн үйлдвэрлэлийн хоцрогдлын хоорондох зөрчил гэж тодорхойлжээ. Энэхүү зөрчлийг шийдвэрлэхийн тулд таваарын аж ахуйг бүх талаар хөгжүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэн, «дөрвөн шинэчлэлт» (аж үйлдвэр, хөдөө аж ахуй, үндэсний батлан хамгаалах, шинжлэх ухаан-техник) -ийг хэрэгжүүлэхийн хамт үйлдвэрлэх-хүчнийг хөгжүүлэх үүднээс үйлдвэрлэлийн харилцаа, давхаргын зарим хэсгийг өөрчлөн байгуулах ажээ.

ХКН-аас социализмын эхний шатанд баримтлах үндсэн чиг шугам бол эдийн засгийн байгуулалтыг анхаарлын төвд байлган, дөрвөн үндсэн зарчмыг* чанд баримталж, шинэтгэл, нээлттэй хаалганы бодлогыг тууштай хэрэгжүүлэн улс орноо ардчилсан, соёлтой, баян, хүчирхэг социалист гүрэн болгохын төлөө тэмцэлд хятадын ард түмнийг нэгтгэн нягтруулж удирдан жолоодох явдал юм гэж тус их хурлаас заасан байна, ХКН-ын X их хурал цаашид хятадын эдийн засгийг хөгжүүлэх стратегийн чиг шугамыг тодорхойлов. Социализмын эхний шатанд үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх явцад Хятад орныг үйлдвэржүүлэх, үйлдвэрлэлийг нийгэмчлэх, тааварлаг шинжтэй болгох, шинэчлэх асуудлыг шийдвэрлэх ажээ. Энэхүү стратегийн зорилтыг гурван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Эхний шатанд 1990 он гэхэд үндэстний нийт бүтээгдэхүүнийг 1980 оныхоос 2 дахин нэмэгдүүлж ард түмний наад захын хэрэгцээг хангах ёстой бөгөөд одоо энэ зорилт үндсэндээ биелэгдсэн.

Хоёрдахь шатанд энэ зууны эцэс гэхэд үндэстний нийт бүтээгдэхүүнийг мөн 2 дахин өсгөж, дунд зэргийн амьдралын түвшинд хүрэх ажээ.

Гуравдахь шатанд ирэх зууны дунд үе болоход нэг хүнд оногдох үндэстний нийт бүтээгдэхүүний хэмжээг дунд зэргийн хөгжингүй орны түвшинд хүртэл нэмэгдүүлж, амьдралын нэлээд чинээлэг байдлыг бий болгох, «дөрвөн шинэчлэлтийг» үндсэнд нь дуусгана гэж төлөвлөжээ.

Өнөө үед 2-р шатны зорилтыг хэрэгжүүлэх явдал гол зүйл бөгөөд эдийн засгийн үр ашиг маш доогуур байгаа нь түүний зангилаа асуудал юм. Энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс:

— шинжлэх ухаан, техник, боловсролыг хөгжүүлэх, — нийгмийн эрэлт хэрэгцээ, хангамжийн тэнцвэртэй байдлыг хангах,

— гадаад харилцааг цаашид өргөжүүлэн гүнзгийрүүлж, гадаад орнуудтай хийх техник-эдийн засгийн солилцоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх ажээ. Тайлан илтгэлд эдийн засгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх явдал аж ахуйн системийг өөрчлөн байгуулах үйл явцыг гүнзгийрүүлэн, түргэтгэхээс шалтгаална гэж цохон тэмдэглээд энэ талаар тавьж буй зорилтыг тодорхойлов. Аж ахуйн системийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх зорилт нь төлөвлөгөөт таваарын аж ахуйн шинэ

*--Социалист хөгжлийн зам, ардын ардчилсан диктатур, ХКН-ын удирдлага, марксизм-ленинизм, маозэдүний үзэл санаа

системийн үндэс суурийг аажмаар тавихын тулд төлөвлөлт, хөрөнгө оруулалт, санхүү, материаллаг нөөц, гадаад худалдааны системүүдийг ээлж дараагаар шинэтгэхэд оршиж байна.

Их хурлын тайлан илтгэлд тэмдэглэсэнээр, социалист төлөвлөгөөт таваарын аж ахуй, капиталист таваарын аж ахуйгаас өмчийн олон хэлбэртэй байдгаараа ялгагддаг бөгөөд таваар солилцоо, өртгийн хуулийг түшиглэсэн төлөвлөлт болон зах зээлийн зохицуулалтыг багтаасан байдаг.

Социализмын эхний шат дахь үйлдвэрлэх хүчний бодит нөхцөл байдлаас үүдэн Хятад оронд аж ахуйн системийг шинэтгэн өөрчилж, Нийгмийн өмч зонхилсон олон хэвшилт аж ахуй, түүний дотор хувийн аж ахуйг ч хөгжүүлэх болжээ. Аж ахуйн системийн шинэтгэлийг түргэтгэн гүнзгийрүүлэхийн тулд:

— өмчлөх болон эрхлэн хөтлөх эрхийг зааглан салгах үндсэн дээр улсын үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг идэвхжүүлэх,

— үйлдвэрлэлийг нийгэмчлэх чухал чиглэл-аж ахуйн томоохон нэгдлүүдийг цаашид байгуулан бэхжүүлэх,

— хэрэглээний зүйл болон үйлдвэрлэлийн хэрэгслийн зах зээл төдийгүй техник-технологи, мэдээлэл, үйлчилгээний зэрэг зах зээлийг багтаасан социалист зах зээлийн системийг бий болгох явцыг түргэтгэн хөгжүүлэх,

— эдийн засгийн удирдлагыг боловсронгуй болгох,

— нийгмийн өмч зонхилсон олон хэвшилт аж ахуйг цаашид хөгжүүлэх зэрэг арга хэмжээ авахаар заасан байна.

ХКН-ын XIII их хурал аж ахуйн системийн шинэтгэлийг өргөжүүлэн гүнзгийрүүлэхийн тулд улс төрийн системийг зайлшгүй өөрчлөн байгуулах хэрэгтэй хэмээн үзэж түүнийг хэрэгжүүлэх арга замыг хэлэлцэн сайшаав.

Улс төрийн системийг өөрчлөн байгуулах гол асуудал бол нам, төрийн байгууллагуудын үүргийг зааглах явдал юм. Нам улс төрийн чиг шугам, зарчмыг тодорхойлох, удирдах боловсон хүчнийг шилж сонгон улсын чухал албан тушаалд тавих зэрэг гол гол асуудлыг шийдвэрлэх зэргээр улс төрийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Үүнээс гадна доод байгууллагуудад эрхийг шилжүүлэх, төрийн аппарат болон боловсон хүчний системийг өөрчлөн байгуулах, нийтээр хэлэлцэн Зөвлөлдөх систем нэвтрүүлэх, улс төрийн ардчиллын ёс журмыг төгөл дөржүүлэх, хууль тогтоомжийг хүчтэй болгох зэрэг арга хэмжээ авна.

Гэвч улс төрийн системийг өөрчлөн байгуулахдаа улс орны тогтвортой байдал, намын нэгдэл нягтралд саад учруулалгүй, алхам алхмаар, хянуур болгоомжтой, тодорхой хязгаартайгаар хэрэгжүүлэх ажээ.

Хятад орны өвөрмөц нөхцөлд социализм байгуулах нарийн төвөгтэй үйл явцыг удирдах, ХШ их хурлаас дэвшүүлсэн зорилтыг амжилттай биелүүлэхийн тулд ХКН-аас онол-улс төр, үзэл суртал зохион байгуулалтын ажлыг хүчтэй болгож, намын байгууллагуудын дайчин чадварыг эрс дээшлүүлэх шаардлага зүй ёсоор гарч ирж байна. Мөн түүнчлэн олон жил улс төр, үзэл сурталын гүнзгий хямралд орж, янз бүрийн кампани, цэвэрлэгээнд өртөж үзэл суртал, зохион байгуулалтын талаар хүнд цохилт хүлээсний уршиг дагавар болон шинэтгэд, нээлттэй хаалганы бодлого явуулж буй шинэ нөхцөл байдалтай уялдан гарч ирсэн нэлээд ноцтой асуудлуудыг шийдвэрлэх явдал ХКН-ын өмнө тулгарч байна.

Юуны өмнө ХКН-ын XIII их хурлаас боловсруулсан социализмын эхэн шатны тухай онолын үндэслэл, тухайн шатанд баримтлах намын үндсэн чиг шугам нь нийт намын гишүүд, ялангуяа удирдах боловсон хүчний үзэл суртлыг нэгтгэх чухал шижим болж байна. Их хурлын тайлан илтгэлд, цөөн тооны намын гишүүд хөшүүн хэвшмэл үзэлд баригдсан буюу марксизмыг үгүйсгэж байгааг тэмдэглээд, намын дотор байгаа алдаатай үзэл суртлын эсрэг улс төрийн кампани өрнүүлэлгүй, гагцхүү хүмүүжүүлэн ойлгуулах, зүй зохисоор нь шүүмжлэх замаар тэмцэх ажээ. Өнөөгийн шатанд ХКН-аас улс төр, үзэл суртал, хүмүүжлийн ажлын талаар тавьж буй зорилт нь намын бүх шатны байгууллагууд нийт намын гишүүдийн дунд намын үндсэн чиг шугам болон намын тухай үндсэн мэдлэг олгох ухуулга, хүмүүжлийн ажил явуулж, бүх гишүүд, ялангуяа удирдах боловсон хүчний үзэл суртал, үйл ажиллагааны нэгдлийг хангах, тэднийг намаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө ухамсартай тэмцэгчид болгоход чиглэжээ. Хамтын удирдлагын журам болон төвлөн удирдах ардчилсан зарчмыг Төв Хорооноос эхлэн хэрэгжүүлэн хэвшүүлэх үүднээс Улс төрийн Товчооны Байнгын хороо УТТ-нд, УТТ Төв Хорооны бүгд хуралд өөрийн ажлаа тайлагнадаг журам тогтоох, намын төв байгууллагуудын (УТТ, УТТ-ы Байнгын хороо, ТХ-ны нарийн бичгийн дарга нарын газар) дүрэм гаргах, намын удирдах боловсон хүчний хоорондын хяналт, харилцан нөлөөллийг хүчтэй болгох зэрэг арга хэмжээ авахаар тогтжээ.

ХКН-ын XIII их хурлын илтгэлийн гадаад харилцааны асуудлыг хөндсөн хэсэгт дунд ба ойрын тусгалын пуужингийн талаархи Зөвлөлт Америкийн зарчмын тохиролцоог талархан үзэж байгаагаа илэрхийлсэн байна. Цаашид энх тайванч, хараат бус, биеэ даасан гадаад бодлогыг хэлбэрэлтгүй явуулж, энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр дэлхийн бүх улс оронтой найрамдал, хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлэх тухай тэмдэглэв. БНХАУ ХКН-ын ХП их хурлаас (1982) гадаад бодлогын талаар дэвшүүлсэн чиг шугамыг үндсэндээ үргэлжлүүлж байгааг их хурлаас хойшхи, үйл явдал харуулж байна.

БНХАУ-ын улс төрийн амьдралд томоохон үйл явдал болсон ХКН ын ХШ их хурал Хятад орны социалист байгуулалтын өнөөгийн байдал, шинэтгэл, нээлттэй хаалганы бодлого хэрэгжүүлэн 9 жилийн үр дүнг нэгтгэн дүгнэж, улмаар улс орон социализмын эхэн шатанд байгаа тухай онолын үндэслэл боловсруулан цаашдын чиг бодлогын тулгуур үндэс болголоо.

Үйлдвэрлэх хүчин хоцрогдонгүй, таваарын аж ахуй хөгжөөгүй Хятад оронд социализмыг бүтээн байгуулах оновчтой арга хэлбэрийг эрж хайх замд цаашдын хөгжлийн стратеги, тактикийн чиг шугамаа боловсруулсан ХКН-ын ХШ их хурлын шийдвэр нь БНХАУ-ын нийгмийн дэвшил хөгжилд чухал нэгэн үе шат боллоо.